



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 11647

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн
эмнэлгийн данс бүртгэлд хөрөнгө
бүртгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 4,804,860.0 /дөрвөн сая найман зуун дөрвөн мянга найман зуун жаран/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг /Б.Галсанцэдэн/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг /Б.Галсанцэдэн/-т үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 121 дугаар
 сарын 24 өдрийн 1/697 тоот тушаалын хавсралт



Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ /төгрөгөөр/		Хөрөнгө оруулалт	
							Нэг бүрийн үнэ	Нийт дүн	Нэр	Эх үүсвэр
1	Өвчтөний эвхдэг ор	Төмөр болон даавуун	1 хүний эвхдэг ор	2019	ш	20	240,243	4,804,860	Улаан загалмай нийгэмлэг	Хандив
Тавилга эд хогшлын дүн								4,804,860		
Нийт бүртгэх хөрөнгийн дүн								4,804,860		